



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОМА-2026/045/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Даланзадгад хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд  
Утас: 70533552 Цахим хаяг: [shijirboldg@audit.gov.mn](mailto:shijirboldg@audit.gov.mn)

Аудитор: О.Чойдорж  
Утас: 70533552 Цахим хаяг: choidorjo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Албан шаардлага.....	10
3.3 Зөвлөмж.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 221  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ДАЛАНЗАДГАД СУМЫН 9 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Л.БАЙГАЛМАА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Илүү цагийн нэмэгдэл хөлсийг зөрүүтэй тодорхойлсноос албан хаагчид 3,809.2 мянган төгрөг дутуу олгосон, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжид ногдох 1,484.0 мянган төгрөг, нүүрсний хөнгөлөлт 8,200.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2, Сангийн сайдын 2025 оны "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын сайдын шийдвэрээр албан хаагчдад 5.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг сар бүр тооцож олгосон байна.

4626050355

F32 Бичиг хэрэг 2026 он ICT-н дүгнэлт Төсөл Досх

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 1,421,433.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,389,706.8 мянган төгрөг зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Даланзадгад сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 30,956.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийлүүлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

## **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан				
Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	211,321,609.20	48,224,261.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		211,321,609.20	48,224,261.03
3121	Төгрөг		211,321,609.20	48,224,261.03
31211	Төрийн сангийн харилцах		211,321,609.20	48,224,261.03
35	БАРАА МАТЕРИАЛ	6	89,175,911.98	90,299,669.98
351	Түүхий эд материал		255,000.00	255,000.00
35130	Эм боох материал		255,000.00	255,000.00
354	Хангамжийн материал		88,920,911.98	90,044,669.98
35410	Бичиг хэргийн материал		2,590,300.00	2,364,300.00
35460	Хүнсний материал		8,650,490.00	2,666,937.00
35470	Бусад хангамжийн материал		77,680,121.98	85,013,432.98
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		300,497,521.18	138,523,931.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,492,244,382.48	1,376,850,029.59
392	Биет хөрөнгө		1,308,169,382.48	1,192,775,029.59
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,646,717,682.10	1,646,717,682.10
39202	Хуримтлагдсан элэгдэл		(532,621,115.16)	(629,486,861.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		145,340,827.10	164,322,904.10
39206	Хуримтлагдсан элэгдэл		(43,832,642.48)	(69,840,531.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		75,246,311.30	78,482,536.90
39208	Хуримтлагдсан элэгдэл		(28,844,940.74)	(35,447,301.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө		77,959,900.00	77,959,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(31,796,639.64)	(39,933,299.52)
393	Биет бус хөрөнгө		184,075,000.00	184,075,000.00
39301	Програм хангамж		1,372,400.00	1,372,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,372,400.00)	(1,372,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		184,075,000.00	184,075,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,492,244,382.48	1,376,850,029.59
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,792,741,903.66	1,515,373,960.60
51	Засгийн газрын хувь оролцоо		1,792,741,903.66	1,515,373,960.60
511	Засгийн газрын оруулсан капитал/Засгийн газрын сан/ орон нутгийн сан		435,375,099.44	435,375,099.44
512	Хуримтлагдсан үр дүн		256,119,312.79	(21,248,630.27)
51210	Өмнөх үеийн үр дүн		256,119,312.79	257,450,056.79
51220	Тайлант үеийн үр дүн		-	(278,698,687.06)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,101,247,491.43	1,101,247,491.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,792,741,903.66	1,515,373,960.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,792,741,903.66	1,515,373,960.60

### **2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан				
Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,051,557,050.00	964,381,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		959,653,500.00	829,770,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		959,653,500.00	829,770,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		91,621,100.00	134,610,200.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		91,621,100.00	134,610,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		282,450.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		282,450.00	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,335,215,869.17	1,270,446,223.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		283,658,819.17	306,065,123.00
120	Нийтлэг татварын бус орлого		283,658,819.17	306,065,123.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		232,798,243.07	262,228,371.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		230,315,843.07	262,228,371.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		2,482,400.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		50,153,076.10	37,896,752.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		707,500.00	5,940,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,292,851,449.72	1,549,144,909.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,244,060,539.74	1,522,588,300.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		746,592,950.64	985,832,762.42
210101	Үндсэн цалин		493,897,322.72	630,214,608.12
210102	Нэмэгдэл		231,701,327.92	307,759,864.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	26,970,000.00
210104	Урамшуулал		20,994,300.00	20,888,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		91,074,530.12	119,480,942.75
210201	Тэтгэврийн даатгал		63,103,267.82	82,119,544.06
210202	Тэтгэмжийн даатгал		7,745,955.40	9,437,523.05
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,754,177.81	4,719,877.97
210204	Ажилгүйдлийн даатгал		3,294,205.81	4,644,166.35
210205	Эрүүл мэндийн даатгал		13,176,923.28	18,559,831.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		67,409,650.02	106,175,591.09
210301	Гэрэл, цахилгаан		9,787,614.02	11,691,779.75
210302	Түлш, халаалт		33,022,726.00	73,592,251.34
210303	Цэвэр, бохир ус		24,599,310.00	20,891,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал		8,064,801.00	-
210408	Бараа материал акталсны зардал		8,064,801.00	-
2105	Нормативт зардал		136,813,982.00	118,355,517.00
210502	Хоол, хүнс		136,813,982.00	118,355,517.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7,617,700.00	3,000,000.00
210604	Урсгал засвар		7,617,700.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,079,900.00	5,191,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,079,900.00	5,191,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		183,407,025.96	184,551,937.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		27,975,828.00	25,280,633.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,456,900.00	5,980,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		146,974,297.96	153,291,104.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		48,790,909.98	26,556,608.91
2132	Бусад урсгал шилжүүлэг		33,527,904.00	1,122,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		282,450.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		33,245,454.00	1,122,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		15,263,005.98	25,434,608.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		15,263,005.98	25,434,608.91
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,292,851,449.72	1,549,144,909.22

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		42,364,419.45	(278,698,686.22)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0.52	0.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		0.52	0.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(0.52)	(0.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		42,364,418.93	(278,698,687.06)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,281,872,893.07	1,226,609,471.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,315,843.07	262,228,371.00
120	Нийтлэг татварын бус орлого	230,315,843.07	262,228,371.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	230,315,843.07	262,228,371.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	230,315,843.07	262,228,371.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,051,557,050.00	964,381,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	959,653,500.00	829,770,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	959,653,500.00	829,770,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,621,100.00	134,610,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,621,100.00	134,610,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	282,450.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	282,450.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,152,827,027.76	1,389,706,819.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,152,827,027.76	1,389,706,819.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,104,036,117.78	1,363,150,210.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	746,592,950.64	985,832,762.42
210101	Үндсэн цалин	493,897,322.72	630,214,608.12
210102	Нэмэгдэл	231,701,327.92	307,759,864.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	26,970,000.00
210104	Урамшуулал	20,994,300.00	20,888,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,074,530.12	119,480,942.75
210201	Тэтгэврийн даатгал	63,103,267.82	82,119,544.06
210202	Тэтгэмжийн даатгал	7,745,955.40	9,437,523.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,754,177.81	4,719,877.97
210204	Ажилгүйдлийн даатгал	3,294,205.81	4,644,166.35
210205	Эрүүл мэндийн даатгал	13,176,923.28	18,559,831.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,638,094.02	106,175,591.09
210301	Гэрэл, цахилгаан	10,016,058.02	11,691,779.75
210302	Түлш, халаалт	33,022,726.00	73,592,251.34
210303	Цэвэр, бохир ус	24,599,310.00	20,891,560.00
2105	Нормативт зардал	142,775,085.00	112,371,964.00
210502	Хоол, хүнс	142,775,085.00	112,371,964.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,720,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	8,720,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,079,900.00	5,351,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,079,900.00	5,351,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,155,558.00	30,937,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,748,658.00	21,902,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,406,900.00	9,035,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,790,909.98	26,556,608.91

2132	Бусад урсгал шилжүүлэг	33,527,904.00	1,122,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	282,450.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,245,454.00	1,122,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,263,005.98	25,434,608.91
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,263,005.98	25,434,608.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	129,045,865.31	(163,097,348.17)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	129,045,865.31	(163,097,348.17)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		211,321,609.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,224,261.03

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,375,099.44	1,101,247,491.43	256,119,312.79	1,792,741,903.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,330,744.00	1,330,744.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,375,099.44	1,101,247,491.43	257,450,056.79	1,794,072,647.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(278,698,687.06)	(278,698,687.06)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,375,099.44	1,101,247,491.43	(21,248,630.27)	1,515,373,960.60

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,162,971,200.00	938,946,491.09
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,028,361,000.00	829,770,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,028,361,000.00	829,770,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,610,200.00	109,175,591.09
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	393,072,500.00	262,228,371.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	393,072,500.00	262,228,371.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,556,043,700.00	1,201,174,862.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,556,073,700.00	1,364,272,210.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,556,073,700.00	1,364,272,210.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,075,819,000.00	985,832,762.42
210101	Үндсэн цалин	706,626,500.00	630,214,608.12
210102	Нэмэгдэл	340,027,500.00	307,759,864.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт		26,970,000.00
210104	Урамшуулал	29,165,000.00	20,888,290.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,391,900.00	119,480,942.75
210201	Тэтгэврийн даатгал	89,873,200.00	82,119,544.06
210202	Тэтгэмжийн даатгал	10,629,700.00	9,437,523.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,314,800.00	4,719,877.97

210204	Ажилгүйдлийн даатгал	5,314,800.00	4,644,166.35
210205	Эрүүл мэндийн даатгал	21,259,400.00	18,559,831.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,610,200.00	106,175,591.09
210301	Гэрэл, цахилгаан	20,988,000.00	11,691,779.75
210302	Түлш, халаалт	74,042,600.00	73,592,251.34
210303	Цэвэр, бохир ус	36,579,600.00	20,891,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	158,183,600.00	112,371,694.00
210502	Хоол, хүнс	158,183,600.00	112,371,694.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,720,000.00	8,720,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,351,600.00	5,351,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,351,600.00	5,351,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,687,400.00	30,937,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,652,200.00	21,902,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	9,035,200.00	9,035,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,000,000.00	1,122,000.00
232	Бусад урсгал шилжүүлэг	10,000,000.00	1,122,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,000,000.00	1,122,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,051,446,500.00</b>	<b>1,281,872,893.07</b>
2	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>1,556,043,700.00</b>	<b>1,364,272,210.26</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		211,321,609.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		48,224,261.03

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 118,837.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 118,837.5 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулахад бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл 1,330.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг /төлөвлөгөө/ Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүн /төлөвлөгөө/ 116,426.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 920.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал засварын зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 160.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маяг"-ийн дагуу бэлтгээгүй

Аудитаар нийт 117,106.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 490.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 108,864.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7,751.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 16,647.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,718.9 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Төлбөрийн акт

**Илрүүлэлт:1** Тайлант хугацаанд илүү цагийн нэмэгдэл хөлс тооцохдоо нэг магт ногдох дундаж цалин хөлсийг зөрүүтэй тодорхойлсноос шалтгаалан 5 албан хаагчид нийт 490.2 мянган төгрөг илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2-д "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно..." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 3.2 Албан шаардлага

**Илрүүлэлт:1** Тайлант онд нягтлан бодогч, няравт 2,664.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2025 оны "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт:2** Албан хаагчдад ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг гаргаж танилцуулаагүй.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 191 дугаар тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.3-т "Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийн дагуу энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг байгууллагын холбогдох нэгж болон ажилтанд олгоно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Илрүүлэлт:3** Тайлант хугацаанд илүү цагийн нэмэгдэл хөлс тооцохдоо нэг цагт ногдох дундаж цалин хөлсийг зөрүүтэй тодорхойлсноос 17 албан хаагчдад 3,809.2 мянган төгрөг дутуу олгосон.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2-д "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсийг тодорхойлохдоо тулайн ажилтны сүүлийн 3 сарын цалин хөлсөөр тооцно..." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Илрүүлэлт:4** Тайлант хугацаанд албан хаагчдад 88,598.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг нэмэгдэл хөлс тооцох хуудсаар баталгаажуулаагүй олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлгийн 1-д "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Илрүүлэлт:5** Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон 2 ажилтанд 4,108.0 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг тооцож олгоогүй.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 5.17-д "Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1-т Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан даагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Илрүүлэлт:6** Албан хаагчтай хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахдаа хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжид ногдох 1,484.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2025 оны "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай тус тус нийцэхгүй байна.

**Илрүүлэлт:7** Тайлант онд албан хаагчдад 8,200.0 мянган төгрөгийн нүүрсний хөнгөлөлтийг цалингийн зардлаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2025 оны Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай тус тус нийцэхгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:1** Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулгахад ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 8 нэр төрлийн 41 ширхэг 7,751.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөн хөрөнгүүдийг жагсаалтыг гаргаж цаашид хэрхэн шийдвэрлэх саналыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлж, саналаа аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэх, үлдэх өртөггүй хөрөнгө ашиглахгүй байх

#### **2. Хөдөлмөрийн хэм хэмжээтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:2** Эрхлэгчийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/71 дугаар тушаалаар 25 албан хаагчдад нүүрсний хөнгөлөлт олгохдоо хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд мөнгөн дүн, дээд хязгаар, тооцоолох аргачлалыг тодорхой тусгаагүй, олгосон байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд нөхөх төлбөр олгох мөнгөн дүн, дээд хязгаар, тооцоолох аргачлалыг тодорхой тусгаж ажиллах

#### **3. Нөхөх олговортой холбоотой асуудал**

**Илрүүлэлт:3** Төсөв захирагч өөртөө шийдвэр гаргаж 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/71 дугаар тушаалаар нөхөх төлбөр олгохдоо нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг хүчингүй болсон хавсралт маягтаар гаргасан байна.

**Өгсөн зөвлөмж:** Монгол Улсын Их хурлын байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар" маягтын дагуу гаргаж ажиллах зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

##### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулахад бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл 1,330.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн	1	1,330.7	1	1,330.7			1	1,330.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг /төлөвлөгөө/ Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүн /төлөвлөгөө/ 116,426.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	116,426.8	1	116,426.8			1	116,426.8				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 920.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	920.0			1	920.0	1	920.0				
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал засварын зардлыг мөнгөн гүйлгээний тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 160.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	160.0			1	160.0	1	160.0				
2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Санхүүгийн тайлангийн маягт"-ийн дагуу бэлтгээгүй	1	0.0			1	0.0	1	0.0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>118,837.5</b>	<b>2</b>	<b>117,756.0</b>	<b>3</b>	<b>1,080.0</b>	<b>5</b>	<b>118,837.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант хугацаанд илүү цагийн нэмэгдэл хөлс тооцохдоо нэг магт ногдох дундаж цалин хөлсийг зөрүүтэй тодорхойлсноос шалтгаалан 5 албан хаагчид нийт 490.2 мянган төгрөг илүү олгосон	1	490.2	1	490.2								
Тайлант онд нягтлан бодогч, няравт 2,664.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн сангаас олгосон	1	2,664.0			1	2,664.0						
Албан хаагчдад ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг гаргаж танилцуулаагүй	1	0.0			1	0.0						
Тайлант хугацаанд илүү цагийн нэмэгдэл хөлс тооцохдоо нэг цагт ногдох дундаж цалин хөлсийг зөрүүтэй тодорхойлсноос 17 албан хаагчдад 3,809.2 мянган төгрөг дутуу олгосон	1	3,809.2			1	3,809.2						
Тайлант хугацаанд албан хаагчдад 88,598.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг нэмэгдэл хөлс тооцох хуудсаар баталгаажуулаагүй олгосон.	1	88,598.9			1	88,598.9						
Өндөр настны тэтгэвэр тогтоолгосон 2 ажилтанд 4,108.0 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг тооцож олгоогүй.	1	4,108.0			1	4,108.0						
Албан хаагчтай хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахдаа хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжид ногдох 1,484.0 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон.	1	1,484.0			1	1,484.0						
Тайлант онд албан хаагчдад 8,200.0 мянган төгрөгийн нүүрсний хөнгөлөлтийг цалингийн зардлаас олгосон.	1	8,200.0			1	8,200.0						

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулгахад ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 8 нэр төрлийн 41 ширхэг 7,751.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө байна.	1	7,751.7					1	7,751.7			
Эрхлэгчийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/71 дугаар тушаалаар 25 албан хаагчдад нүүрсний хөнгөлөлт олгохдоо хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд мөнгөн дүн, дээд хязгаар, тооцоолох аргачлалыг тодорхой тусгаагүй, олгосон	1	0.0					1	0.0			
Төсөв захирагч өөртөө шийдвэр гаргаж 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/71 дугаар тушаалаар нөхөх төлбөр олгохдоо нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг хүчингүй болсон хавсралт маягтаар гаргасан	1	0.0					1	0.0			
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>117,106.3</b>	<b>1</b>	<b>490.0</b>	<b>7</b>	<b>108,864.1</b>	<b>3</b>	<b>7,751.7</b>			

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 44,740.6 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 49,660.6 мянган төгрөгийн 1 гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 2 шийдвэрийг тус тус мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 775,361.2 мянган төгрөгийн 19 гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн.	1	869,762.5			1	869,762.5		
<b>ДҮН</b>	1	869,762.5			1	869,762.5		